

Ерөнхий боловсролын бодлогын зөвлөх багийн “Багшийн загвар боловсруулах” ажлын хэсгийн тайлан

Нэг. Ажлын үндэслэл

Мэргэжилтэн бэлтгэх, ялангуяа багшлах боловсон хүчин бэлтгэх, тэднийг хөгжүүлэх нь бие дааж өөрөө хөгжих чадвартай, ЗӨВ МОНГОЛ ХҮН-ийг төлөвшүүлэх, бүтээлч, өрсөлдөх чадвартай хүний нөөцийн чадавхийг өсгөн нэмэгдүүлэх чухал хариуцлагатай ажил билээ.

Дэлхийн олон улс орон **“Боловсролыг нэгдүгээрт” санаачлагад** нэгдэж, **чанартай, хүртээмжтэй, цаг үеийн шаардлагад нийцсэн боловсролыг хүүхэд бүрд үр дүнтэй эзэмшүүлэх** үүргийг биелүүлж чадах, багшийг бодлоготойгоор бэлтгэх, тэдний тогтвортой хөгжих нөхцлийг бүрдүүлэхийг багш боловсролын шинэчлэлийн тэргүүлэх зорилго болгон тавьж байна.

XXI зуунд багшийн ажил үүрэгт гарч буй үндсэн өөрчлөлт нь багш бэлтгэх тогтолцоог шинэчлэхийг зүй ёсоор шаардаж байна. Шинэ зуунд багш нь сургагчаас илүүтэй зөвлөн туслагчийн, мэдээлэл дамжуулагчаас илүүтэй суралцах орчин нөхцөлийг бүрдүүлэгч, суралцах боломжийг олгох менежерийн хийгээд боловсролын ЧАНАРЫН шинэчлэлийн манлайлагчийн үүргийг гүйцэтгэх болж байгаа нь багш бэлтгэх сургалтын агуулга, арга зүй, үнэлж дүгнэх тогтолцоо, түүнчлэн багшийн хөгжлийг дэмжих ажлын арга барилыг шинэчлэх хэрэгцээг буй болгож байна.

Улс орны болон дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагын энэхүү өөрчлөлтийг бодитойгоор мэдэрч, ойлгосны үндсэн дээр дэвшүүлсэн шинэчлэлийн Засгийн газрын **“Эрдэм боловсролтой монгол хүн”** хөтөлбөр нь багш бэлтгэх, багш тасралтгүй хөгжих тогтолцооны өнөөгийн нөхцөл байдлыг өөрчлөн сайжруулах дорвитой эрэлт хайлт хийх сэдлийг өгч байна.

Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн **“Эрдэм боловсролтой Монгол хүн”** хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх боловсрол, шинжлэх ухааны салбарын чанарын шинэчлэлийн ажилд багш бэлтгэдэг сургуулиудад тавих шаардлага, стандартыг өндөржүүлэх, багш бэлтгэх сургуульд элсэх босгыг дээшлүүлэх үйл ажиллагааг төлөвлөсөн билээ.

Шинэчлэлийн засгийн газрын **“Зөв монгол хүүхэд”** хөтөлбөрийг бодит амьдралд хэрэгжүүлэх, боловсролын чанарын шинэчлэлд тууштай түшиг тулгуур

болох 21-р зууны **Монгол багшийн загварыг** багшийг эрхэмлэн шүтэж ирсэн Монгол ардын уламжлал, шинэ зууны эхээр багш боловсролын хүрээнд Монгол оронд хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүд, бусад улс орны туршлага, судалгааны тайлангууд, шинэчлэлийн засгийн газрын “Эрдэм боловсролтой Монгол хүн” хөтөлбөр, боловсролын чанарын шинэчлэлийн үзэл санаанд үндэслэн боловсруулав.

Хоёр. Өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын төр засгаас багш бэлтгэх болон мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн бодлого, хөтөлбөр¹, тогтоол шийдвэрүүд²-ийг гаргаж, хэрэгжүүлж ирсэн хэдий ч багш бэлтгэх бүх шатны сургууль, бэлтгэн гаргаж буй мэргэжилтний мэдлэг, чадвар, хандлага нийгмийн болон хувь хүний өнөөгийн болоод хэтийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Тухайлбал, Азийн хөгжлийн банкны санхүүгийн дэмжлэгтэй хэрэгжсэн “Сургалтын хөтөлбөрийн бүтэцчилсэн хүрээ, боловсролын стандарт боловсруулах техникийн туслалцаа, зөвлөх үйлчилгээ” төслийн багаас 2009 онд гаргасан тайланд багшлах боловсон хүчин бэлтгэх ажлын чанар тун хангалтгүй байгааг тэмдэглээд, үүний шалтгааныг сургалтын агуулгаас илүүтэй түүнийг зохион байгуулж буй арга барил, хандлага, харьцаа, соёл дутагдаж³ байгаатай холбон үзжээ. Мөнхүү зөвлөх үйлчилгээний багаас “... багш бэлтгэж ирсэн уламжлалт тогтолцоондоо дүн шинжилгээ хийж, дэлхийн улс орнуудын багш бэлтгэдэг тогтолцооны дэвшилттэй арга хэлбэрүүдээс санаа авч одоогийнхоос илүү **чанар, үр өгөөжтэй тогтолцоог бий болгох** ажлыг нэн яаралтай эхлүүлэх”⁴-ийг зөвлөсөн байна.

МУБИС-д түшиглэн хэрэгжсэн “Багш-2005” төсөл (2002-2005)-ийн хүрээнд хийсэн судалгаанд оролцсон ахлах ангийн сурагчид (846) багш нарыгаа **харилцааны соёлгүй (65%), хүүхдийг ойлгох, тэдэнд туслах чадвар дутмаг (49%), хувийн үлгэр дуурайлал муутай (13%)**⁵ гэж үнэлжээ.

“Багш-2005” төслийн багаас, багш нарын “нийгмийн болон хувь хүний боловсролжих хэрэгцээний хувьслыг цаг алдалгүй тооцож чадахгүй байгаа, бүх мэргэжлийн суралцагчдад ижил зүйлийг нэгэн хэвийн аргаар зааж байгаа, ихийг заах буюу цаг нэмэгдүүлэх сэтгэлгээ хэвээр байгаа зэрэг туршлага сургамж”⁶-ийг цаашдын шинэчлэлд авч үзэхийг анхааруулсан байдаг. Энэ нь хүүхэд нэг бүрийн

¹ “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2008 оны 316 дугаар тогтоол

² “Ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтыг батлах тухай” БСШУ-ны сайдын 2007 оны 10-р сарын 05-ны өдрийн 351-р тушаал; “Багшлах эрх олгох, хасах журам батлах тухай”, БСШУ-ны сайдын 2008 оны 11-р сарын 13-ны өдрийн 74-р тушаал; “Багшийн мэргэжлийн зэрэг олгох, хасах журам батлах тухай” БСШУ-ны сайдын 2008 оны 11-р сарын 13-ны өдрийн 73-р тушаал

³ “Сургалтын хөтөлбөрийн бүтэцчилсэн хүрээ, боловсролын стандарт боловсруулах техникийн туслалцаа, зөвлөх үйлчилгээ”, Эцсийн тайлан, 3-р боть, 4-р ном, х. 84/218

⁴ Мөн тэнд, х. 81/218

⁵ Эрдэнэчулуун Д., “Нэгжид суурилсан судалгааны үр дүнгээс”, УБ. 2003, х. 22

⁶ Жадамбаа Б., Батсуурь Ц., Пүрэв-Очир Б., Пүрэвдорж Д., “Багш боловсролын ирээдүй”, УБ. 2005, х. 66

хэрэгцээ, сонирхлыг судалж, хөгжүүлэх эрхэм үүргээ зарим багш гүйцэтгэж чадахгүй байгааг (магадгүй ийм чадвар дутагдаж буйг) сануулж байна. Ийм байдал цаашид үргэлжилвэл багшийн нэр хүнд, нийгмийн үнэлэмж доошлох, боловсролын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй.

МУБИС-ийн БШСТТөв (Боловсролын шинэчлэлийг судлан түгээх төв)-өөс 2011 онд хийсэн “Багш боловсролын чанарыг сайжруулах нөхцөл байдлын судалгаа”-ны тайланд, шинэ багш нарт **ажилдаа сэтгэлээсээ, хариуцлагатай ханддаггүй, хувийн зохион байгуулалт сул, хүнлэг чанар дутмаг, бүтээлч биш** гэх зэрэг дутагдал түгээмэл илэрч байгааг⁷ дурджээ.

Энэ нь багшид ажилдаа хандах бүтээлч хандлага, хариуцлага төдийлөн сайн төлөвшихгүй байгааг илтгэж байна. Мөн тайланд багш бэлтгэх сургуулийн сургалтын чанар, ялангуяа, анхан шатны багш боловсрол (initial teacher education) төдийгүй төгсөгчийн чанарт тавих стандарт үгүйлэгдэж буйг дурдсан байна.

Багшийн ажил нь хувь хүний олон талын шинж, эрхэм чанарыг шаардсан ажил тул багш бэлтгэх сургуульд элсэгчдэд тавих шаардлагыг нэмэгдүүлэх хэрэгтэйг олон нийтийн зүгээс шаардаж байгаа⁸-г “Монгол-Кэмбриджийн Боловсролын санаачлага”-ын багаас зөвлөжээ.

Ийнхүү дотоод, гадаадын судлаачдын судалгааны баримтад тулгуурласан дүгнэлтээс багш бэлтгэх сургууль төгсөгчдийн бүтээлч хандлага, ажил хэрэгч хариуцлагатай чанар, шинжлэх ухаанч сэтгэлгээ хангалтгүй байгаа нь өнөөгийн шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг гэж үзэж байна.

Гурав. Зорилго, зорилт

Судалгааны ажлын **зорилго** нь хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэмд ажиллаж, амьдрах чадвартай, өөртөө итгэлтэй, монгол хэл, түүх, соёлоо дээдэлдэг, суралцах хүсэл тэмүүлэлтэй, эрдэм боловсролтой монгол иргэний хөгжил, төлөвшилд хувь нэмрээ оруулж чадах багш мэргэжилтний загвар буюу шинэ зууны монгол багшийн эзэмших үндсэн чадамжийн бүтэцчилсэн хүрээг боловсруулахад оршино.

Дээрх зорилгод хүрэхийн тулд дараах **зорилтыг** тавьж ажиллав. Үүнд:

- ❖ Багш бэлтгэх, багшийг хөгжүүлэх ажлын чанарыг сайжруулах зорилгоор хийсэн судалгааны материалуудад шинжилгээ хийж, өнөөгийн байдлыг тодруулах
- ❖ Багш боловсролын хөгжлийн чиг хандлагыг шинжлэх

⁷ Энхтүвшин С., Баттуяа Ц., Сумъяа Ц., “Багш мэргэжлийн стандартын харьцуулсан судалгаа-2011”, УБ, 2011, х. 25

⁸ Монгол-Кэмбриджийн Боловсролын санаачлага., Чиглэл-8, Багш бэлтгэх боловсролын талаар санал болгож буй үйл ажиллагаанууд., 2012 оны 6-р сарын семинарийн материал, 16/5

- ❖ Бусад улс орны 21-р зууны багшийн загвар, багшийн эзэмших чадамжийн бүтэцчилсэн хүрээг боловсруулсан туршлагыг судалж, ашиглаж болох санаа, туршлагыг нэгтгэн дүгнэх
- ❖ Шинэ зууны Монгол багшийн загварын хувилбарыг боловсруулах
- ❖ Уг загварыг хэрэгжүүлэх механизмыг тодорхой болгох
- ❖ Загварыг цаашид юунд, хэрхэн ашиглах талаар санал, зөвлөмж гаргах

Дөрөв. Арга зүй

Судалгааг холистик (holistic) чиг хандлагаар явуулж, чанарын дүн шинжилгээний аргуудыг түлхүү хэрэглэлээ. Багш боловсролын талаар баримталж буй бодлого, шийдвэрүүд, үндэсний хэмжээнд хэрэгжсэн хөтөлбөрүүд, багш бэлтгэх сургалтын агуулга, арга зүйг шинэчлэх хэрэгцээ шаардлагыг судалсан нөхцөл байдлын судалгаануудын тайланд шинжилгээ хийхийн зэрэгцээ бусад улс орны багшийн загваруудыг харьцуулан судлав.

Судалгааг дараах үе шаттай явуулав. Үүнд:

- I. Багш боловсролын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход жинтэй хувь нэмэр оруулсан олон улсын дээд хэмжээний уулзалт, эрдэм шинжилгээний бага хурлуудын тайлан болон багш бэлтгэх, багшийг хөгжүүлэх талаар Монгол улсын төр засгаас баримталж буй хөгжлийн бодлого, стратеги, урт болон дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг тодорхойлсон баримт бичгүүдийг судлах;
- II. Бусад улс орны 21-р зууны босгон дээр багш боловсролын бодлогоо тодорхойлох, багш-мэргэжилтний эзэмших үндсэн чадамжийн бүтэцчилсэн хүрээг тодорхойлсон загварууд, багшийн бэлтгэлд тавих чанарын шаардлага, стандартыг боловсруулахад ашигласан түгээмэл загваруудыг харьцуулан судлах;
- III. Багш бэлтгэх сургалт, багшийг тасралтгүй хөгжүүлэх ажлын шинэчлэл, ялангуяа чанарын өөрчлөлтийг хэмжихэд ашиглах багшийн стандартын бүтэцчилсэн хүрээг тогтоох эх суурь болж чадах багшийн загварын хувилбарыг боловсруулах;
- IV. Боловсруулсан хувилбарыг ерөнхий боловсролын бодлогын зөвлөх багийн гишүүд болон салбарын эрдэмтэд, мэргэжилтнүүдэд танилцуулж, хэлэлцүүлэх;
- V. Багшийн загварын хувилбарт өгсөн санал шүүмжийн дагуу засан сайжруулж, БШУЯ-нд танилцуулах;

Судалгаанд баримт бичгийн шинжилгээ, харьцуулсан судалгааны болон хийсвэрлэх, загварчлах аргыг үндсэн арга болгон ашиглав.

Харьцуулсан судалгааны эквивалент хэмжилт бүрдүүлэхдээ улс бүрд ижил хувьсагч хэрэглэх, эсвэл улс бүрд өвөрмөц хувьсагч хэрэглэх арга замын эхнийхийг сонгож, харьцуулалтыг дараах зүйлээр хийв. Үүнд:

- ❖ 21-р зууны босгон дээр багш бэлтгэх сургалтын агуулгыг шинэчлэхэд тулгуурласан бүтэцчилсэн хүрээ
- ❖ Багш мэргэжилтний эзэмших үндсэн чадамжууд, багшийн стандартыг боловсруулахдаа тулгуурласан “багш”-ийн загвар
- ❖ Багшийн загварын зориулалт, хэрэглээ

Харьцуулан судлах улс орнуудыг дараах үндэслэлээр сонгов. Үүнд:

- ❖ “Багш” мэргэжилтний эзэмших үндсэн чадамжууд, тэдгээр чадамжид тулгуурласан стандартыг боловсруулж, хэрэглэсэн олон жилийн баялаг туршлагатай орон болох АНУ, Англи
- ❖ Суралцагчид нь олон улсын хэмжээнд зохион байгуулагддаг үнэлгээний судалгаа (PISA, TIMSS)-нд сүүлийн жилүүдэд өндөр амжилт гаргасан улс орнууд: Финлянд, Сингапур
- ❖ “Багш” мэргэжилтний эзэмших цогц чадамжийг олон улсын хамтарсан төслийн хүрээнд боловсруулж, хэлэлцэж батлах үйл явцад олон орны эрдэмтэн судлаач оролцдог Европын холбооны орнуудыг тус тус сонгон авсан болно.

Тав. Судалгааны мэдээлэл, боловсруулалт

5.1. Багш боловсролын чанарыг сайжруулах бодлогын баримт бичигт хийсэн шинжилгээ

“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”⁹ -д “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого нь хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм дэх монгол хүний хөгжлийг хангах, тус улсын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологи, соёл иргэншлийг эрчимтэй хөгжүүлэхэд чиглэсэн ирэх арван дөрвөн жилийн бодлогыг дэлхий нийт, бүс нутгийн хөгжилтэй нягт уялдуулан цогцоор тодорхойлж байна” хэмээн өгүүлсэн нь боловсролыг шинэчлэх дэлхий нийтийн чиг хандлага, хүнээ, улсаа хөгжүүлэхийн тулд боловсролоо хөгжүүлэх гэсэн бодлого үзэл баримтлалыг Монголын төр засгаас дэвшүүлснийг илтгэж байна.

Мөн “Боловсрол үндэсний хөтөлбөр”¹⁰-т (2010-2021 он) Монгол Улсын боловсролын салбарын 2021 он хүртэл хэрэгжүүлэх үндсэн зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Энэхүү зорилтод “бүх шатны боловсролын тогтолцооны нийгмийн шинэ шаардлагад нийцсэн тасралтгүй хөгжлийг хангаж, боловсролын үйлчилгээний хүртээмжид баримжаалсан бодлогоос **боловсролын чанар, үр**

⁹ www.forum.mn/policyissue/NationalDevelopment/Strategy.doc. Монгол улсын их хурлын 2008 оны 12-р тогтоолын хавсралт. “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”. х. 2.

¹⁰ www.mecs.gov.mn. Монгол улсын засгийн газрын 2010 оны 31-р тогтоолын хавсралт. “Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010-2021 он).

өгөөжийг тогтмол дээшлүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлэхэд чиглэсэн бодлогод шилжих нь боловсролын шинэчлэлийн онцлог байна” гэж онцлон тэмдэглэжээ. Энэ нь боловсролын салбарын хөгжлийг боловсролын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн цогц зорилгод хүрэх арга замаар үндэсний боловсролыг олон улсын түвшинд ойртуулан шинэчлэл хийхийг сануулж байна.

“Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”¹¹ -ийн зорилгод “Багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх тогтолцоог ерөнхий боловсролын сургуулийн бүтцийн өөрчлөлт, **цогц чадамжид суурилсан боловсролын стандарт** болон сургалтын хөтөлбөрийг суралцагчдын эрэлт хэрэгцээнд тохируулан хэрэгжүүлэх чадвартай багш бэлтгэх, багшийн мэргэшил, арга зүйг тасралтгүй дээшлүүлэх, цаашид тогтвортой хөгжих нөхцөлийг хангахад оршино” гэж тодорхойлжээ. Үүнийг бид багш бэлтгэх сургуулийн төгсөгчдөд тавих наад захын шаардлага нь юуны өмнө өнөөгийн зах зээл дэх багшийн хөдөлмөрт баримжаалсан, багш бэлтгэх сургалтын чанарыг сайжруулахад чиглүүлэн боловсруулахыг шаардаж байна гэж үзэж байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь зорилтуудыг дэвшүүлжээ.

Тухайлбал, зорилт 1-ийн хүрээнд **багш боловсрол, багш боловсролын стандартын талаар** “Багш” боловсролын зорилго, агуулга, бага, дунд боловсролын чанарыг тасралтгүй сайжруулах хэрэгцээ шаардлага, ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, хэв шинжийн онцлогт нийцсэн зах зээл дэх багшийн хөдөлмөрийн эрэлт нийлүүлэлтэд баримжаалсан, багш бэлтгэх нээлттэй, уян хатан, тогтвортой тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэх, **“Багш” боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэн мөрдөх** зэрэг зорилтыг дэвшүүлжээ. Энэ ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тогтсон байна. Үүнд:

- **“Багш” мэргэжилтний загварыг шинэчлэн тодорхойлж, түүнд нийцсэн “Багш” боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан мөрдөж, байнга сайжруулж байх;**
- Сургалтын хөтөлбөрт тусгагдсан багшлах дадлагын хэсгийн зохион байгуулалтыг институтчилах;
- **Багшийн мэргэжлээр суралцагчдын сургалтын чанарыг дээшлүүлэх;**
- Багш мэргэжлээр суралцагчдыг мэргэжлийн сурах бичгээр хангах асуудлыг шийдвэрлэх;
- Багш бэлтгэх сургуулийн профессор багш нарын чадавхийг дээшлүүлэх;
- **“Багш” боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадвартай боловсон хүчин бэлтгэх, чадавхижуулах** цуврал сургалтыг тодорхой төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;
- “Багш” боловсролын талаархи судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх;
- Боловсролын хавсарга болон **туршилт судалгааны төслийг** Монгол Улсын их сургууль, **Монгол Улсын Боловсролын их сургуульд төвлөрүүлэн** боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын

¹¹ www.mecs.gov.mn Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 316-р тогтоолын 1-р хавсралт. “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”.

захиалгаар гүйцэтгүүлэх зэрэг чухал чухал арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тогтон, хэрэгжүүлж байна.

Шинэчлэлийн засгийн газрын (2012-2016) “Эрдэм боловсролтой монгол хүн” боловсролын хөтөлбөрийн хүрээнд хийх ажил, хэрэгжүүлэх хөтөлбөрүүд (“Зөв Монгол хүүхэд”, “Багшийн хөгжил” гэх мэт) нь тооноос илүү **чанарыг эрхэмлэж**, Монгол хүүхэд нэг бүрийн авьяас чадвар, сонирхол, хөгжих боломж бололцоог нь танин мэдэх суурь судалгаа явуулж, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга замаа мэддэг багшийг бэлтгэх, тэднийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэж¹² байна.

Монгол улсын боловсролын салбарын өөрчлөлтийн хүрээн дэх бодлогын баримт бичгүүд багш боловсролын чанар өгөөжийг хэрхэн сайжруулах талаар тодорхой арга замуудыг ийнхүү заажээ.

5.2. Өнөөгийн Монгол багшийн төлөв байдал

Багш бэлтгэх боловсролын тогтолцоог шинэчлэх “БАГШ – 2005” хөтөлбөрийн хүрээнд Монгол улсад багш бэлтгэж байгаа одоогийн тогтолцоонд дүн шинжилгээ хийх, өнөөгийн багшийн ерөнхий дүр төрхийг тогтоох судалгааг профессор Д.Эрдэнэчулуун ахлагчтай МУБИС-ийн судалгааны баг 2003 онд хийсэн байдаг. Уг судалгаанд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 846 сурагч, 178 эцэг эх, багш бэлтгэх сургуулийн 231 оюутан, ерөнхий боловсролын сургуулийн 70 багш, сургуулийн удирдах ажилтан, аймаг, хотын боловсролын газрын арга зүйчид 103 хүн оролцсон аж. Судалгааны багийн тайланд багш нар өнөөгийн шаардлагыг дундаж түвшинд (62%) хангаж байгааг тэмдэглээд, оролцогчдын багаахан хэсэг (8%) шаардлага хангаж чадахгүй байна¹³ гэж үзсэнийг анхааруулсан байдаг.

Сайн багшийн тухай төсөөллөө судалгаанд оролцсон сурагчид дараах байдлаар хуваалцжээ. Үүнд:

- ❖ Хичээлээ ойлгомжтой заадаг
- ❖ Зөв боловсон харилцдаг
- ❖ Сурагчдаа сайн ойлгодог, илэн далангүй, тэднийг дэмждэг, дотны туслагч
- ❖ Тал бүрийн мэдлэгтэй, боловсролтой
- ❖ Алиа хошин зантай
- ❖ Хүүхдийг ялгаварлахгүй, шударга үнэлдэг
- ❖ Үлгэр дууриалалтай
- ❖ Компьютер, гадаад хэлний мэдлэгтэй
- ❖ Зарчимч, өндөр шаардлага тавьдаг

Харин хүүхдэд таалагддаггүй багшийн дутагдалд дараах шинж тэмдгийг тоочсон байна:

- ❖ Харилцааны соёлгүй (65%)
- ❖ Заах арга барил муутай (49%)
- ❖ Амьдралын түвшин, царай зүс, гадна өнгө үзэмжээр ялгаварладаг (38%)
- ❖ Ширүүн догшин авиртай, уурлаж, загнадаг (33%)

¹² Монгол улсын засгийн газар, Боловсрол, шинжлэх ухааны яам, “Эрдэм боловсролтой Монгол хүн” Боловсрол шинжлэх ухааны салбарын чанарын шинэчлэлийн хөтөлбөр, 2012, х. 5-11.

¹³ Эрдэнэчулуун Д., “Нэгжид суурилсан судалгааны үр дүнгээс”. УБ. 2003, х. 11.

- ❖ Хэл амаар доромжилж, гутаадаг (33%)
- ❖ Сурагчдыг шударга бус үнэлдэг (31%)
- ❖ Мэдлэг муу (14,7 %)
- ❖ Хувийн үлгэр дууриалал муу (13%)
- ❖ Хичээл заахгүй орж гардаг (12%)
- ❖ Архи уудаг, авилгал авдаг (8%)

Хүүхэдтэй хийсэн ярилцлагын баримтад тулгуурлан, судалгааны баг: "...багш, сурагчдын хооронд тодорхой зөрчил гардаг бөгөөд тэдгээрийн ихэнх нь багшийн харилцаа болон хүмүүжлийн доголдлоос шалтгаалан үүсдэг"¹⁴ гэж үзсэн байна.

Судалгаанд оролцсон эцэг эхчүүд өнөөгийн багш нарын мэдээлэлтэй ажиллах арга барил дээшилсэн, сургалтын орчин үеийн аргыг хэрэглэж байгаад сэтгэл ханамжтай байсан бол, хүүхдийг хөгжүүлэх, хүмүүжүүлэх тал дээр ажилладаггүй, үл ойлголцох, үл итгэлцэх явдал ажиглагддаг, цөөн тооны сайн хүүхэдтэй ажиллаад, тааруу нэгийг зөнд нь хаядаг, хүүхэдтэй харилцах эв дүй, соёл дутмаг, хүүхэдтэй ширүүн догшин, бүдүүлэг харилцдаг, хүүхдийг өнгө мөнгөөр дүгнэдэг дутагдалд шүүмжлэлтэй хандсан байна. Судлаачдын баг, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд **соёлч боловсон харилцаа, багшийн хувийн үлгэр дууриалал, ёс суртахууны төлөвшил, хүүхэдтэй ажиллах арга барил дутагдаж байна** гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг.

Энэ байдал өнөөг хүртэл өөрчлөгдөөгүй байгаа нь найман жилийн дараа (2011 он) МУБИС-ийн Боловсролын шинэчлэлийг судлан түгээх төв (БШСТТ)-өөс хийсэн судалгааны үр дүнгээс мөн л ажиглагдаж байна. Асуулга судалгаанд оролцсон төв, баруун, зүүн, хойд бүсийн аймгийн сургуулиудын 384 багшаас түүвэрлэн авсан, 11 бүлгийн ярилцлагын (нэг бүлэг нь 8-12 хүнтэй) материал болон 20 гаруй сургуулийн удирдах ажилтантай хийсэн ганцаарчилсан ярилцлагын баримтад хийсэн чанарын анализаас дараах дүр зураг харагдаж байна.

- *Шинэ багш нар тун хангалтгүй бэлтгэгдэж ирж байна*¹⁵;
- *Мэргэжлийн онолын мэдлэг дутмаг байна;*
- *Төлөвлөх чадвар сул байна. Иймд шинэ багшид хөтөлбөр хэрхэн боловсруулах зэргийг заах, дахин ажиллах шаардлагатай болдог;*
- *Сэтгэл их дутаж байна. Үүнд багшийн ажилд дур сонирхолгүй байдал нь нөлөөлж байх шиг харагддаг;*
- *Үүрэг хариуцлага хүлээх чадваргүй;*
- *Бичгийн соёл, бичиг баримт боловсруулах чадвар дутмаг. Маш их алдаатай бичдэг;*
- *Хүүхэд судлах, оношлох мэдлэг чадвар хангалтгүй;*
- *Хүүхдийг бодитой үнэлж, дүгнэж чадахгүй байна;*
- *Заах арга зүй дутмаг. Сургалтын шинэлэг аргуудыг сонссон боловч хэрэглэж чадахгүй байна;*
- *Эзэмшсэн мэдлэг нь ЕБС-ийн агуулгын стандарттай уялдаа холбоогүй;*
- *Багшлахуйн тухай мэдлэг хангалтгүй. Хичээлийн судалгаа, нэгж хичээлийн хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар тодорхой ойлголтгүй байна;*
- *Харилцааны соёл муутай;*

¹⁴ Мөн тэнд, х. 22.

¹⁵ Гурваас дээш фокус бүлгийн ярилцлагад давтагдсан санааг судалгааны тайланд налуу шрифтээр ялгаж бичсэн байв.

- Ажил дээр гарсан бэрхшээлийг даван туулах, шийдвэрлэх чадвар сул, шантрамтгай;
- Бүтээлч биш, дээрээс ирэх заавар, загвар хүлээдэг;
- Ажлаа тайлагнаж, тайлбарлаж чаддаггүй;
- Дүгнэлт, дүн шинжилгээ хийх чадвар сул¹⁶.

Дээрх бүлгийн ярилцлагад оролцсон багш, удирдах ажилтнууд шинэ багш нарт дараах дутагдал түгээмэл илэрч байгааг бас тэмдэглэжээ. Үүнд:

- *Ажилдаа сэтгэлээсээ, хариуцлагатай ханддаггүй*
- *Хувийн зохион байгуулалт сул*
- *Хайнга, хайхрамжгүй*
- *Бүтээлч биш*
- *Өөрийн алдаа дутагдлыг хүлээх, бусдыг сонсох дургүй*
- *Бусдаас суралцдаггүй*
- *Хүнлэг чанар дутмаг*
- *Өөрийгөө таних чадвар сул*
- *Хүүхдийг ойлгох, хайрлах чадвар дорой*

Энэхүү бүлгийн ярилцлагын зарим баримтаас толилуулвал:

*Сайн багш бэлтгэхийн тулд багш бэлтгэх сургуулиуд нийгмийнхээ нөхцөл байдлыг судалж үзээд, өнөөгийн нийгэмд ямар зүйл хэрэгтэй байгаа, **орчин үеийн багшаас юу шаардаж байгаа, орчин үеийн хүүхдүүдэд юу шаардлагатай байгааг маш өргөн хүрээтэй судалж гаргаж ирээд, түүнийхээ үндсэн дээр өөрсдийнхөө сургалтын хөтөлбөрүүдийг үндсээр нь өөрчлөх хэрэгтэй. Тэгэхгүй бол, нөгөө л 80-аад оны юмыг яриад л явж байна ш дээ. Хавтас нь шинэчлэгдсэн боловч, доторхи нь хуучин агуулга. Би тэгж л боддог . . .***

Бүлгийн ярилцлагаас

*Оюутан байхад сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлалын хичээлээр том том онол сонсоод, том том онолын номнуудыг хуулаад л байсан. Багш нар том том онол, рефлекс, дохионы систем энэ тэр гээд л . . . , нохой, гахайн дээр туршсан юм яриад л байдаг . . . Яг үнэнийг хэлэхэд, нэг хүүхдээс судалгаа аваад, тэр **хүүхдийнхээ суралцах чадварыг тодорхойлох ч юм уу, түүнийхээ үр дүнг практикт яаж хэрэглэх тухай заадаггүй л байхгүй юү.***

Залуу багш нарын бүлгийн ярилцлагаас

Дээрх ярилцлагын баримтаас багшид хүүхэд нэг бүрийг судлах, хөгжүүлэхэд чиглэсэн арга барил дутагдаж байгаа нь харагдаж байна. Багш нар маань багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэхийг хүлээж байгаагаа бас илэрхийлжээ.

¹⁶ Энхтүвшин С., Баттуяа Ц., Сумъяа Ц., “Багш мэргэжлийн стандартын харьцуулсан судалгаа-2011”, УБ, 2011, х. 24.

Дээрх судалгаануудын үр дүнг бүхэлд нь нэгтгэн үзвэл, багш нарын мэргэжлийн болон хувь хүний төлөвшлийн байдал тун чамлалтай байна. Багш бэлтгэж буй сургууль нь тодорхой шинжлэх ухааны боловсрол эзэмшүүлэхэд түлхүү анхаараад, багш – бие хүнийг төлөвшүүлэх, ялангуяа тэдний эрхэмлэх үнэт зүйл, ажилдаа, улмаар хүүхэд-суралцагчдад хандах эерэг хандлага төлөвшүүлэх, тэднийг хүнтэй ажиллах эв зүй, чадвар эзэмшүүлэх тал дээр хангалтгүй ажиллаж ирснийг харуулж байна.

Иймд хүүхэдтэй ойр дотно ажилладаг, тэдэнд чин сэтгэлээсээ хандаж, туслаж, зөвлөдөг, харилцааны соёлтой, бие даан ажиллаж, өөрийгөө хөгжүүлэх чадвар бүхий шинэ үеийн багш нарыг бэлтгэх, хөгжүүлэхэд дараагийн шатны судалгаа, үйл ажиллагаа чиглэгдэх ёстой.

5.3. Багшийн загварын хувилбаруудад хийсэн шинжилгээ

1980-1990-ээд онд АНУ, Англи, Австрали зэрэг оронд сайн багш буюу үр өгөөжтэй багш нь юу хийх ёстойг илрүүлэхийг зорьсон судалгааны ажлуудыг дэмжсэний үр дүнд багшийн чадамжийг судалсан олон бүтээлүүд гарч, практикт нэвтэрсэн байна. Ялангуяа 1990-ээд оны дунд үеэс багшлахуй ба суралцахуйн чанарыг сайжруулах төсөл, хөтөлбөрийн хүрээнд багшийн чадамжийн **бүтэцчилсэн хүрээг тогтоох** судалгааны ажлууд амжилттай хийгдэж, багшийн ажлыг шинээр эхлэн хийж буй мэргэжилтнүүдийн эзэмших чадамжийн бүтэцчилсэн хүрээг тодорхойлсон баримт бичгүүдийг боловсруулан гаргажээ. Харин 1990-ээд оны сүүл үед Австрали, Англи гэх зэрэг оронд стандарт боловсруулахад илүүтэй төвлөрч, “Багш” мэргэжлийн, ялангуяа **шинэ багшийн** (зарим оронд багшлах эрх олгох) **стандартыг** боловсруулахдаа багшийн тодорхой загварт тулгуурласан байна. XXI зууны **багш мэргэжлийн профессиограммыг** тодорхойлохдоо “багш боловсрол” судлаачид (teacher educators) дараах дөрвөн үндсэн загварыг онцлон авч үзсэн байх юм. Эдгээр загваруудад тулгуурлан багш боловсролын хөтөлбөрүүдээ боловсруулдаг туршлага ч байна. Үүнд:

1. “**Үр өгөөжтэй/сайн багш**” (effective teacher) **загвар** нь багш боловсролын стандарт, багшийн чадамжуудын хамт сүүлийн 30-аад жил засгийн газрын албан ёсны хэлэлцүүлгүүд, бодлогын баримт бичгүүдэд дэвшигдэн гарч ирсэн. Хүүхэд, залуучуудыг үндэсний эдийн засгийг амжилтанд хүргэх нэг гол хүчин зүйл болох хүний нөөц болгон чанартай бэлтгэхийн тулд багш, түүний бэлтгэл, хөгжилд анхаарлаа төвлөрүүлэх ёстой гэсэн үзлийг баримталдаг **боловсрол үр өгөөжтэй**, эдийн засгийн хувьд ашигтай байх тухай санааг дэмждэг бөгөөд **техник гүйцэтгэл, хэмжилтийг** онцлон авч үздэг. Mahony, Hextall (2000) нарын тодорхойлсноор¹⁷, энэ загвар нь **хариуцлага** ба **гүйцэтгэлийг** онцгойлон авч үзэж буй үед илүүтэй хэрэглэгддэг юм байна.

Шинэ эриний багш нарын Карнегийн Корпорацаас 2001 онд багшийн чанарыг сайжруулах замаар суралцагчдын сурахуйн амжилтыг ахиулах төслийг санаачилсан нь уг загварын хөгжилд томоохон түлхэц болсон түүхтэй. Судалгаанд хамрагдсан олон орон эл загварт тулгуурлан шинэ багшийн стандартаа боловсруулсан байв.

2. “**Эргэцүүлэгч багш**” (reflective teacher) **загварыг** америкийн боловсрол судлаач Джон Дьюи (1916) багшийг идэвхтэй шийдвэр гаргагч болгон бэлтгэх

¹⁷ Pat Mahony, Ian Hextall (2000). Literature Review on Teacher Education in the 21st Century.

тухай концепцийг гаргаж ирснээр үндэслэсэн гэж үздэг. Улмаар америкийн судлаач Доналд Шон “Практик эргэцүүлэгч” (1983) бүтээлдээ багш мэргэжилтний үнэт зүйлийн ач холбогдлыг авч үзэж, судалгааны баримт мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах онолоо¹⁸ боловсруулсан нь багш мэргэжлийн профессиограммыг тодорхойлох шинэ парадигм/загвар болж хөгжихөд үнэтэй хувь нэмэр оруулсан байна.

Английн судлаач Андрю Поллард “Багшлахуйн эргэцүүлэл” (1987-2008) бүтээлдээ багшлах үйл ажиллагааны төлөвлөлтийн цикл хандлагыг тодорхойлсон¹⁹ нь анги танхимын нөхцөл/контекстэнд суралцах боломжийг бүрдүүлэх, мэргэжил нэгтэнтэй хамтарч ажиллах, сурагчдад санал-зөвлөгөө (feedback) өгөх үйлийг шинэ багшийн стандарт, багш боловсролын хөтөлбөрүүдэд тусгахад чухал хувь нэмэр оруулжээ.

Форд (2006) нарын судлаачдын үзсэнээр, эргэцүүлэгч багшийн загвар нь дангаараа багшийн ажлыг судалгааны чиг хандлагатай болгоход дэмжлэг үзүүлж чаддаггүй²⁰ байна.

3. “Шинжлэн судлаач багш” (inquiring teacher) загвар нь багшийн хөгжилд онцгой ач холбогдол өгдөг. Судлаач Лауренс Стенхаус (1975) багш ажилдаа судалгааны үүднээс хандах санааг дэвшүүлж, уг загварыг үндэслэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан. Тэрээр багшлах үйл ажиллагааны судалгаанд **хөтөлбөрийн судалгаа** чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзээд, энэ нь дараах боломжийг багшид олгодог²¹ болохыг тэмдэглэжээ:

- Анги танхим дахь үйл ажиллагаагаа системтэй шинжлэх
- Практик үйл ажиллагаанаасаа суралцах, хөгжих
- Шинэ соргог зүйлийг мэргэжил нэгтэнтэй хуваалцах

АНУ, Австрали, Англи улс уг загварт үндэслэсэн **үйлийн судалгааг** шинэ багшийн стандарт, улмаар багш боловсролын хөтөлбөртөө суулгаж өгсөн байна. Энэхүү үйлийн судалгаа нь багшид өөрийн судалгааны талаар ул суурьтай, шүүмжлэлтэйгээр бодож сэтгэх боломжийг олгодог аж.

4. “Өөрчлөн шинэчлэгч багш” (transformative teacher) загвар нь нийгмийн өөрчлөлтөд хувь нэмрээ оруулах **нийгмийн үүрэг хариуцлага**, суралцагчдыг нийгмийн өөрчлөлтөд бэлтгэх мэргэжлийн хариуцлагад онцгой ач холбогдол өгдөг. Нийгмийн тэгш биш байдлыг арилгах, нийгмийн дэвшилтэт өөрчлөлтүүд нь боловсролоор, бүр тодруулбал багшийн үйл ажиллагаагаар дамжин хийгддэг утгаараа багш нь нийгэм, улс төрийн өөрчлөлтийн төлөө ажилладаг мэргэжилтэн²² (Жүди Сакс, 2003) гэж үздэг байна. Ийм ч учраас нийгмийн шударга ёсыг бэхжүүлэхэд **багшийн итгэл үнэмшил, үнэт зүйл** чухал рольтой²³ болохыг Кларк, Друдид (2007) нарын судлаачид онцлон тэмдэглэжээ. Судалгаанд хамрагдсан АНУ, Англи, Шотланд, Сингапур зэрэг орон үнэт зүйл, хандлагыг багшийн эзэмшвэл зохих чадамжийн үндэс суурь болгон авч үзсэн байв.

Дээрх дөрвөн төрлийн загвар зонхилох чиг хандлагатай байгаа ч зарим улс орны багшийн загварыг онцлон авч үзвэл:

¹⁸ Donald A. Schon (1983). The reflective practitioner: how professionals think in action.

¹⁹ Andrew Pollard (2008). Reflective Teaching.

²⁰ Forde et al, (2006). Literature Review on Teacher Education in the 21st Century. www.scotland.gov.uk

²¹ Lawrence Stenhouse (1975). The Teacher Researcher.

²² Judyth Sachs (2003). The activist teaching profession. Open University press.

²³ Clarke, M. & Drudy, S. (2007). Social Justice in Initial Teacher Education: Student Teachers' Reflections.

АНУ: 1992 онд InTASC (Interstate Teacher Assessment and Support Consortium) буюу багшийг үнэлэх болон тэдэнд дэмжлэг үзүүлэх муж дундын консорциумаас үр өгөөжтэй багшийн загварт тулгуурласан **багшийн жишиг стандартыг** гаргасан түүхтэй. Энэхүү жишиг стандартад үндэслэн муж улс бүр шинэ багшид багшлах эрх/лиценз олгох стандартыг боловсруулан мөрдөж ирсэн бөгөөд 2011 онд шинэчлэн боловсруулахдаа манлайлагч (өөрчлөн шинэчлэгч багшийн загвартай төстэй) багшийн загварт тулгуурлан боловсруулжээ.

Энэхүү шинэчлэн боловсруулсан стандартаас багшийн мэргэжлийн мэдлэг, хандлага, гүйцэтгэлийг тэдний дадлага туршлагатай уялдуулан цогц авч үзсэн нь бидний анхаарлыг татаж байв. Эдгээр гурван бүрдэл хэсгийн холбоо хамаарлыг дахин бүтэцчилж, **гүйцэтгэлийг** багшлах практикт ажиглаж, үнэлж болохоор зүйлийн нь хувьд **хамгийн эхэнд** авч үзсэн нь бусад орноос ялгарч буй нэгэн онцлог гэлтэй. “Үндсэн мэдлэг” нь баримтын болон үйлдийн (хийх аргын тухай) мэдлэгээс бүрдэнэ. Энэ нь практик үйл ажиллагааг үр дүнтэй болгоход чухал үүрэг гүйцэтгэнэ гэдгийг тодорхой илэрхийлсэн байна. “Нэн чухал хандлагууд” нь багш бодит байдал дээр хэрхэн хийж үйлдэхэд багшийн ажилдаа хандах, хүүхдэд хандах хандлага, мэргэжлийн үйл ажиллагааны хэвшил, багшийн ёс суртахуун хичнээн чухал үүрэгтэй болохыг онцлон авч үзсэн нь авууштай туршлагын нэг мөн гэж үзэж байна.

АНУ-ын багшийн стандартад тодорхойлсон багшийн заавал эзэмших үндсэн чадамжийн бүтэцчилсэн хүрээ



Англи: Багшийн эзэмших үндсэн чадамжийн хүрээнд мэргэжилтэн бие хүний шинж, хандлагад тавих шаардлагыг хамгийн эхэнд авч үзсэн байв. Тухайлбал, хүүхдээс хүсэн хүлээж буй эерэг хандлага, үнэт зүйлс, зан үйлийг багш өөрийн

биеэр үлгэрлэн харуулдаг байх, ажлын байрны бодлого, үйл ажиллагааны талаар мэдлэгтэй, тэдгээрийг хэрэгжүүлэх хамтын хариуцлага хүлээхэд бэлэн, бусдын зөвлөгөөг авахад нээлттэй хандах гэх зэрэг шаардлага тавьжээ.

Багшийн мэргэжлийн мэдлэг, ойлголтын хүрээнд мэдээлэл харилцааны технологийг сургалтын үйл ажиллагаандаа хэрхэн ашиглахаа мэддэг байх нь бусад орныхтой адил боловч багш бүр мэдээлэл харилцааны технологийн мэргэжлийн ур чадварын тест өгсөн байх шаардлага тавьснаараа ялгаатай байв.

Багшийн мэргэжлийн ур чадварын хүрээнд суралцахуйг үнэлэх, хяналт шинжилгээ/мониторинг хийх чадварт санал, зөвлөгөө (feedback) өгөх чадварыг нилээд онцлон үзсэн байна. Мөн суралцах орчны асуудлыг онцгойлон анхаарч, суралцах чиг зорилго бүхий таатай орчин бүрдүүлэх, сургуулиас гадуур суралцах боломжийг тодорхойлж чаддаг байх нь багш мэргэжилтний бас нэгэн чухал чадвар аж.

Английн багшийн стандартад тодорхойлсон багшийн заавал эзэмших үндсэн чадамжийн бүтэцчилсэн хүрээ



Сингапур: 2004 онд Сингапурын Боловсролын Үндэсний хүрээлэн багш бэлтгэх хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, үнэлсэн байна. Шинэ багш нарын эзэмших эрхэм чанаруудыг үнэт зүйлс, ур чадварууд, мэдлэгийн хүрээ гэсэн бүтэцтэйгээр шинэчлэн боловсруулжээ. Багш бэлтгэх асуудлыг авч үзэхдээ **багш бэлтгэх сургалтыг онцолдог** уламжлалт хандлагаас татгалзаж, “**багш боловсрол**”-д онцгой ач холбогдол өгч, бүтэцчилсэн хүрээгээ боловсруулан гаргажээ.

Сингапурын боловсролын яамнаас гүйцэтгэлийг нэмэгдүүлэх менежментийн тогтолцоог бодлоготойгоор боловсруулж, хэрэгжүүлсэн нь багш, боловсролын


ажилтнуудад өөрсдийгөө мэргэжлийн хувьд хөгжүүлэх, үндсэн чадваруудаа сайжруулахад нь нөлөөлсөн байна. Энэхүү тогтолцоо Сингапурын сургуулийн менежментэд 2003 оноос нэвтэрсэн аж. Энэ нь мэдлэг, чадвараас гадна **мэргэжилтэн бие хүний чанарыг шаарддаг чадамжид суурилсан гүйцэтгэлийн менежментийн тогтолцоо** юм (Сингапурын боловсролын яам, 2004).

Багшийн үнэт зүйл, ур чадвар, мэдлэгийн бүтэцчилсэн хүрээг багшийн чанар, багш нарын ажлын мөн чанарт гарч буй өөрчлөлт, багшид тавьж буй шинэ шаардлага зэрэгт төвлөрүүлэн боловсруулсан байна. Багшийн зайлшгүй эзэмших ур чадвар, мэдлэгийн бүрдэл хэсгүүдийг сургалтын хөтөлбөрт шингэсэн гол үнэт зүйлсийн хамт өргөн утгаар илэрхийлжээ. Энэхүү бүтэцчилсэн хүрээний тусламжтайгаар хөтөлбөрүүдийг боловсруулахдаа шинжлэн судлах, шинэчлэл, эргэцүүлэл, харилцан хүндэтгэл, хувь хүмүүс хоорондын холбоо, хамтын ажиллагаа, олон нийт зэрэг ойлголтуудыг онцлон авч үзсэн байна. Энэхүү бүтэцчилсэн хүрээг багшид багшлахуйн үнэт зүйлээ эргэцүүлэх, практик үйл ажиллагаа, Сингапур сургуульд багшилж, бас суралцахад нь зайлшгүй шаардлагатай мэдлэг, ур чадвар, үнэт зүйлээ хөгжүүлэхэд нь туслах стратеги/арга зам, сурган хүмүүжүүлэх арга барилд тулгуурлан боловсруулсан байна.

Багшийн загвараа **“үнэт зүйлд тулгуурласан загвар”** хэмээн нэрлэсэн нь ч учиртай. Багшийн үнэт зүйлийг загварын буюу бүтэцчилсэн хүрээний цөм болж байгаагийн учрыг дараах үндэслэлээр тайлбарласан байна. Үүнд:

- ❖ Мэдлэг, ур чадвар нь үнэт зүйлд тулгуурладаг
- ❖ Үнэт зүйл нь хувь хүний мөн чанарыг тодорхойлдог бөгөөд энэ нь өөртөө, хүмүүст, ажил үйлдээ ажилдаа хандах хандлагад нөлөөлдөг
- ❖ Үнэт зүйл нь тухайн хүний итгэл үнэмшил, хандлага, үйлээр хэлбэрждэг байна.

Сингапурын үнэт зүйлд тулгуурласан багшийн загвар



Финлянд: Багш нар бол боловсролын шинэчлэлийн гол хөдлөгч хүч бөгөөд тэд мэргэжлийн өндөр, бүтээмжит чадамжийг эзэмшсэн байх шаардлагатайгаас гадна тэдгээрийг нь хянан шинжлэх хэрэгтэй гэж үздэг байна. Багшийн заавал эзэмших чадамжийг академик, сурган хүмүүжүүлэх, соёлын чадамж хэмээн гурван бүлэгт ангилан үзэж байсан уламжлалт хандлагадаа шүүмжлэлтэй хандах болжээ. Багшийн чадамжийн талаар судалсан бүтээлүүдэд шинжилгээ хийж, багшийн мэргэжлийн чадамжийг дахин тодорхойлох олон удаагийн оролдлогын үр дүнд дараах шинэ чадамжийг шинэ зууны эхээр боловсруулан, хэрэглэж байна.



Академик чадамж (field competencies) нь “Сургуульд юу заах ёстой вэ?” гэсэн асуултад илүүтэй хамаарна. Тэдгээр нь **судлах хичээлийн агуулга, түүний академик судалгааг** багтааж байдаг багшийн мэргэжлийн чухал чадамж юм. Нэг талаар багшийн заах, нөгөө талаар суралцагчийн судлах хичээлүүдтэй холбоотой чадамж юм. Багш нар агуулгыг дамжуулах үүрэг хариуцлага хүлээдэг уламжлалт үзэл баримтлалд, академик чадамжийг тухайн шинжлэх ухааны салбарын гол онол, үзэл баримтлалд тулгуурласан хамгийн чухал чадамж гэж үздэг байсан. Заах зүйлээ мэддэг байх тухай үзэл баримтлал, багш анги танхим дахь суралцах үйлийг хариуцна гэсэн ойлголт цаг хугацаа өнгөрөх тусам өөрчлөгдсөөр байна. Энэхүү өөрчлөлтийн хүрээнд багшийн академик чадамжийг, ялангуяа агуулгыг дамжуулах үйлтэй холбон авч үзэх явдал багасч, харин суралцагчдад **агуулгатай ажиллахад нь зөвлөн туслах үүргийг** илүү чухалчлах болж байна.

Судалгааны чадамж (research competencies) нь судалгааны арга, техникүүд, багшлах ажлын явцад хийх судалгаагаа төлөвлөх, хийж гүйцэтгэх дэд чадамжуудыг агуулна. Эл чадамж нь сургалтын хөтөлбөрийн болон боловсролын судалгааг сонирхож буй хүмүүс, мэргэжилтнүүдтэй хамтарч ажиллах боломжийг бүрдүүлнэ. Судалгааны чадамж нь багш нарт салбарынхаа хөгжилд хувь нэмрээ оруулах, түүгээрээ дамжуулан өөрсдийгөө хөгжүүлэхэд нөлөөлдөг байна. Түүнчлэн, суралцагчдын шинжлэх ухааны сэтгэлгээ, ур чадварыг нэмэгдүүлэхэд ч ач тустай. Судалгааны чадамж нь багшийн бүх талын чадамжийг хөгжүүлэхэд

туслаад зогсохгүй багш боловсролын шинэ чиг хандлага болох **судалгаанд тулгуурласан багш боловсролыг** дэмжинэ. Уг чадамжийг хэр эзэмшсэн нь багшийн (ялангуяа төгсөгч, шинэ багшийн) мэргэжлийн ба судалгааны бүтээлийг уншихад бэлтгэгдсэн байдлаар илэрнэ. Багш унших зүйлээ сонгож чаддаг, уншиж буй зүйлээ үнэлдэг, уншсан зүйлээс нь чухам юу нь тэдний практикт хэрэг болохыг мэддэг байх шаардлагатай.

Сургалтын хөтөлбөрийн чадамж (curriculum competencies) нь сургалтын хөтөлбөрийг боловсруулах болон хэрэгжүүлэх гэсэн хоёр дэд чадамжаас бүрдэнэ. Хөтөлбөрийн чадамж нь сургалтын хөтөлбөрийн философийн мэдлэг, сургалтын хөтөлбөр боловсруулах, төлөвлөх, хөтөлбөрийн элементүүд, хөтөлбөр боловсруулах загварууд, түүний гүйцэтгэлийг төлөвлөх арга замууд, хөтөлбөрийн агуулгыг сонгох, зохион байгуулах, боловсруулах үйл явц, багшлах үйлээ төлөвлөх, хөтөлбөр боловсруулах судалгаанд бэлтгэх, нөхцөл байдлыг хянах ур чадваруудаас бүрдэнэ. Сургалтын хөтөлбөрийн чадамж нь багшлах ба суралцах үйл явцыг хөтөлбөрт төлөвлөх үйлтэй нягт холбоотой. Нөгөө талаар, эдгээр чадамж нь багш нарт багшлах үүргээ илүү үр дүнтэй гүйцэтгэх залуур болдог. Хөтөлбөрийн чадамж нь нэг талаас онолын, нөгөө талаас практик чадамжуудтай нягт холбогдоно. Түүнчлэн суралцахуй ба багшлахуйтай холбоотой чадамж болохынхоо хувьд багшийн мэдлэг, ур чадварын хүрээг тодорхойлдог. Хөтөлбөрийн чадамжийг эзэмшихгүйгээр, сургуульд боловсролын үйлчилгээг үр өгөөжтэй үзүүлэх боломжгүй гэж үздэг байна. Финляндын сургалтын хөтөлбөрийн төвлөрсөн бус тогтолцоотой холбоотой нэгэн онцлог бол багш бэлтгэх сургууль төгсөгч нь сургуулийн түвшний сургалтын хөтөлбөрийн төлөвлөлтөд оролцоход бэлтгэгдсэн байх шаардлагатай аж. Үүний тулд мэргэжлийн буюу шинжлэх ухааны хэлээр харилцах, хамтын эргэцүүлэл хийх чадварыг бас эзэмшсэн байна.

Тасралтгүй суралцах (lifelong learning) үйл явц нь суралцагчдаас суралцах үйл ажиллагааныхаа хариуцлагыг өөрсдөө хүлээхийг шаарддаг. Хувь хүнийхээ хувьд багш нар нь өөрсдийн тасралтгүй суралцах үйл явцыг хариуцна. Тасралтгүй суралцах чадамж нь **сурахуйд суралцах чадварууд** болон **мэргэжил дээрээ өсч хөгжих багш нарын хариуцлагаас** бүрдэнэ. Эдгээр чадамж нь суралцах чадвар хийгээд амьдралынхаа турш суралцах үйл явцаа улам сайжруулахад суралцах арга, хэрэгслийг ашиглах ур чадвартай шууд хамааралтай. Тасралтгүй суралцах чадамж нь багш өөрийн суралцах үйл явцаа хариуцах чадвар, мөн суралцагчдын насан туршдаа суралцах чадварыг хөгжүүлэх чадваруудыг багтаана. Өөрөөр хэлбэл, тасралтгүй суралцахуй нь хоёр гол чадвараас бүрдэж байна. Нэг нь багш өөрөө амьдралынхаа турш суралцах чадвар, нөгөө нь суралцагчдынхаа насан туршийн чадварыг хөгжүүлэх багшийн хариуцлага юм.

Сэтгэл хөдлөлийн чадамж (emotional competencies) нь багш нар болон суралцагчдын үнэт зүйл, ёс суртахуун, итгэл үнэмшил, хандлага, зовнил/сэтгэлийн түгшүүр, сэдэл, бусдын сэтгэлийг ойлгох чадвар зэргийг агуулна. Тэдгээр нь сургуулийн хүрээнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сургалтын хөтөлбөрийн зөвлөмжийг хэрэгжүүлэх зэрэгтэй нягт холбоотой. Багш нарын сэтгэл хөдлөлийн чадамж нь суралцагчдын сурахуйд дэмжлэг үзүүлэхэд чухал ач холбогдолтой. Учир нь багш суралцагчдын суралцахуйн сэтгэл хөдлөлийн талыг хэрхэн хөгжүүлэхээ мэдэж байвал тэдний суралцах дур сонирхолд ч нөлөөлнө. Эдгээр чадамж нь багшид суралцагчдынхаа суралцах үйл ажиллагаанд хяналт тавьж чадах үр бүтээлтэй багш болоход нь тусална. Суралцахуй нь сургалтын үйл явцад эерэг хандах мэдрэмжийг буй болгодог сэтгэл хөдлөлийн дэмжлэгүүдийг шаарддаг. Багш нь

суралцагчдынхаа суралцах үйл ажиллагаанд зөвлөгөө өгдөг зөвлөх/ментор байх ёстой.

Нийгэм-соёлын чадамж нь суралцагчид болон багш нарын нийгэм-соёлын нөхцөл байдал, орон нутгийн болон үндэсний, олон улсын үнэт зүйлс, ардчилал, хүний эрхийн асуудлуудын талаархи мэдлэг, бусадтай багаар хамтарч ажиллах хийгээд нийгмийн судалгааны чадварыг багтаана. Энэ бүгд нь суралцагчид болон багш нарт сургалтын үйл явцын эрх чөлөөг олгож, суралцахуйг идэвхжүүлдэг. Хувь хүн нь нийгмийн амьдралд нийгмийн төдийгүй соёлын хувьд оршин байдаг. Ийм маягаар суралцахуй ба суралцагчдын нийгэм соёлын нөхцөл байдлын хооронд нягт холбоо хамаарал буй болдог. Суралцахуйн зарим онолд суралцахуйг нийгэм-соёлын нөхцөл байдал/контекст талаас нь авч үзээд, багш нарын нийгэм соёлын чадамж нь суралцагчдын суралцах үйл ажиллагааг эрчимжүүлэхэд тусална гэж үздэг. Хүмүүнлэгийн болон нийгмийн онолуудыг багш нарын нийгэм-соёлын чадамжийг хэрэглэх замаар л анги танхимын практикт хэрэгжүүлэх боломжтой.

Харилцааны чадамж нь харилцааны загварууд, багш, суралцагчид, нийгмийн орчин, суралцах сэдвүүдийн хүрээн дэх харилцан үйлчлэлийг агуулна. Багш нар аман харилцааны чадамж болон биеийн хэл, мэргэжлийн хэлээ эзэмшсэн байх шаардлагатай. Харилцааны чадамж нь дуу хоолой, биеийн хэл, үг яриа, хүртэх, харааны контакт, бичгийн хэрэглээ зэргийг хамарна. Тэдгээр нь хүмүүс хоорондын харилцааны чадвар болон хүний дотоод/ өөрөө өөртэйгээ харьцах үйл явц, сонсох, ажиглах, ярих, асуух, задлан шинжилгээ хийх болон үнэлэх чадварыг агуулна.

Мэдээлэл харилцааны технологийн – ICT чадамж нь мэдлэг олж авах, дамжуулах хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн хэрэглээнд тулгуурладаг. Тэдгээр нь мэдээллийг боловсруулах, хэрэглэх, хадгалах, харилцах, түгээх үйл ажиллагаанд тус болох аливаа технологийг агуулна. МХТ-ийн чадамжууд нь мэдээллийг хэрэглэх, харилцахад зориулагдсан бүхий л технологийг хамрах **мэдээллийн менежмент болон мэдээлэл боловсруулах технологийн хэрэглээтэй** нягт холбоотой. Энэ нь МХТ-ийн чадамж нь сургалтын үйл явц дахь харилцааг идэвхжүүлэхэд хичнээн чухал ач холбогдолтой болохыг харуулж байна.

Хүрээлэн буй орчны чадамж (environmental competencies) нь экологи, хүрээлэн буй орчны аюулгүй байдлын чадамж юм. Экологийн буюу хүрээлэн буй орчны асуудал нь багшийн тогтвортой хөгжлийн нэгэн хэмжигдэхүүн мөн. Хүрээлэн буй орчныг цэвэр, амьдрах боломжтой байлгах, экологийн нөөцийн менежмент, эко системийн тухай ойлголт, байгалийн нөөцийг боломжид нь тохируулан ашиглах болон нөөцийн боломжит байдал гэх мэт **экологийн систем болон хүрээлэн буй орчны тухай мэдлэг, хандлага, ур чадварыг** хүрээлэн буй орчны чадамж хэмээн тодорхойлж байна.

Зургаа. Судалгааны үр дүн

Тайлангийн эл хэсэгт дэд багийн боловсруулсан шинэ зууны Монгол багшийн загвар (“Монгол багш²¹”), түүний тайлбар болон уг загварыг хэрэгжүүлэх механизмын бүдүүвч (схем)-ийг толилуулах болно.

МОНГОЛ БАГШ²¹

загвар

Хүнлэг энэрэнгүй ёс суртахуунтай
Хүүхдийг хайрлах нинжин сэтгэлтэй

Сурахуйн болон сургахуйн арга ухаантай
Судлан шинжлэх ажилд сэтгэл, зүтгэлтэй

Эцэг эх, хүүхдийн итгэлийг даадаг
Эрхэмлэх зүйл, ноён нуруу сайтай

Хүүхэд бүрээс амжилт хүлээдэг
Хөгжил, төлөвшилд нь цогц ханддаг

Шинэ санаа, шинэчлэлд нээлттэй
Шинийг сэдэх, бүтээх чадамжтай

Монгол хүний унаган төрхийг мэддэг
Монгол эх орноороо бахархуулж чаддаг

багшийг “Шинэ зууны Монгол багш” гэнэ.

МОНГОЛ БАГШ²¹
загвар



МОНГОЛ БАГШ²¹ (21-р зууны Монгол багш)
загварын тайлбар

| | | |
|----------------------|-----------------------|--|
| Эрхэмлэх зүйл | Хүүхдэд ээлтэй | <ul style="list-style-type: none"> ▪ Хүүхдийг ойлгодог, хайрладаг ▪ Суралцагчийн онцлог, ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг ▪ Хүүхэд бүрийг амжилттай сурч чадна гэдэгт итгэдэг ▪ Хүүхэд бүрийн чадавхийг бүрэн дайчлахыг эрмэлздэг ▪ Хүүхдийн хөгжил, төлөвшилд цогц ханддаг |
| | Ёс зүйтэй | <ul style="list-style-type: none"> ▪ Багшийн нэр хүнд ёс зүйг эрхэмлэдэг ▪ Төрийн хууль, дүрэм, журмыг сахин мөрддөг ▪ Зөв үлгэр дуурайлтай ▪ Үндэсний ёс заншлаа дээдэлдэг |
| | Нийцтэй | <ul style="list-style-type: none"> ▪ Мэргэжил нэгт нөхдөө дэмжиж, тусалдаг ▪ Хамтран ажиллагсдын үүрэг, хувь нэмрийг үнэлдэг, ололт амжилтад нь баярладаг ▪ Шинэчлэл, шинэ санааг соргог мэдэрдэг ▪ Баг, нийтийн эрх ашгийг дээдэлдэг ▪ Эцэг эх, хүүхдийн итгэлийг даадаг |
| | Хичээнгүй | <ul style="list-style-type: none"> ▪ Багшлах ажилдаа элэгтэй, чин сэтгэлээсээ ханддаг ▪ Судлан шинжлэх ажилд сэтгэл, зүтгэлтэй ▪ Ажил хэрэгч, хариуцлагатай ▪ Тууштай |
| Суурь чадамж | Хувийн | <ul style="list-style-type: none"> ▪ Үндэсний ёс заншлын дэвшилт уламжлалаа сахих, хөгжүүлэх ▪ Эх хэлээрээ яруу, утга төгс ярих, бичих ▪ Түгээмэл гадаад хэл дээр унших, ойлгох ▪ МХТ-ийг хэрэглэх, харилцах ▪ Өөрийгөө таних, илэрхийлэх, хянах, залах, хөгжүүлэх ▪ Бүтээлчээр сэтгэх ▪ Бие даан ажиллах ▪ Асуудал шийдвэрлэх |
| | Нийгмийн | <ul style="list-style-type: none"> ▪ Идэвхтэй сонсох, хэлэлцэх ▪ Бусдыг ойлгох ▪ Нийгмийн амьдралд оролцох ▪ Зохицон өөрчлөгдөх ▪ Манлайлах, зохион байгуулах |


Мэргэжлийн чадамж

| | |
|--|--|
| <p>Сурган хүмүүжүүлэх зүй, сэтгэл судлал, дидактикийн нэгдмэл мэдлэг, ойлголт</p> | <ul style="list-style-type: none"> ▪ Хүний хөгжил, төлөвшил, нийгэмшихүйн зүй тогтол ▪ Хүүхэд-суралцагчийн хөгжил, төлөвшил, түүнд цогц хандах нь ▪ Багш мэргэжилтэн (өөрийн тухай) ▪ Боловсролын онол, үзэл баримтлал, бодлого, тэдгээрийн хэрэгжилт ▪ Боловсролын эрх зүйн орчин ▪ Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр ▪ Суралцахуй (Суралцагчдын хувийн ялгаа, хэрэгцээ, сонирхол, суралцах хэв шинж; суралцахуйн зонхилох онол, үзэл баримтлал; суралцахуйд үзүүлэх нийгэм, соёлын нөлөө ба өмнөх туршлага; суралцагчийн өөртөө итгэх итгэл, сурах сэдэл; суралцах чадамж) ▪ Сургахуй/багшлахуй (суралцах тав тухтай орчин, түүнийг хэрхэн бүрдүүлэх тухай; тухайн хичээлээр эзэмших мэдлэгийг хэрхэн бүтээх, бүтэцлэх, бусад хичээлийн агуулгатай холбох, амьдралд хэрэглэх тухай; тухайн агуулгыг судлахад тулгардаг нийтлэг ташаа ойлголт, гаргадаг түгээмэл алдаа, тэдгээрийг залруулах арга зам; сургалтын төлөвлөлт, сургалтын аргууд, сонголт, тэдгээрийн хэрэглээ; суралцагчдын бүлэг, анги хамт олонтой ажиллах нь) ▪ Үнэлгээ (сургалтын явцын, үр дүнгийн; багшийн өөрийн үйл ажиллагааны) ▪ Сургууль (Сургууль – хүүхэд бүрийн хөгжин төлөвших, суралцаж, амьдрах орчин) |
| <p>Мэргэжлийн ур чадвар</p> | <ul style="list-style-type: none"> ▪ Судлах, шинжлэх ▪ Суралцах (төрөл бүрийн эх сурвалжаас мэдээлэл цуглуулах, шүүмжлэлтэйгээр үнэлэх, сонгох, шинэ санаа гаргахад бүтээлчээр ашиглах; оюуны үйлийн ерөнхий ба тусгай арга барилыг хэрэглэх) ▪ Сурлцах орчин бүрдүүлэх (суралцагчдын хамтарч ажиллах, харилцан суралцах үйлийг дэмжсэн бодит болон цахим орчин) ▪ Тухайн хичээлээр эзэмших мэдлэгийг бүтэцлэх, бусад хичээлийн агуулгатай холбох ▪ Хичээл, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, баримт нотолгоонд тулгуурлан үнэлэх, үр дүнг танилцуулах ▪ Суралцах үйл ажиллагааг чиглүүлэх, зөвлөх ▪ Тухайн агуулгыг судлахад тулгардаг нийтлэг ташаа ойлголт, гаргадаг түгээмэл алдааг таних, илрүүлэх, тэдгээрийг залруулах ▪ Шинийг сэдэх, хуваалцах, бүтээх ▪ Харилцах (амаар, бичгээр) ▪ Хамтарч ажиллах (суралцагчтай ганцаарчлан болон суралцагчдын бүлэг, анги хамт олонтой) ▪ Мэргэжлийн хамт олны үйл ажиллагаанд оролцох, манлайлах |

| | | |
|------------------------|------------------------|--|
| Академик чадамж | Академик мэдлэг | <ul style="list-style-type: none"> ▪ Тухайн шинжлэх ухааны тулгуур онол, үзэл баримтлал, зарчим, хууль, зүй тогтол ▪ Үндсэн ухагдахуун, нэр томъёо, шинжлэх ухааны хэл, шинжлэн судлах арга, хэрэгсэл ▪ Судлагдахууны үндсэн ухагдахуун, сэдвүүдийг суралцагч хэрхэн ойлгодог туршлага (нийтлэг дүр төрх, нийтлэг жишээ) ▪ Монгол хэл, түүх, соёл, сэтгэлгээний уламжлал |
| | Академик чадвар | <ul style="list-style-type: none"> ▪ Мэргэшиж буй шинжлэх ухааны хэлийг хэрэглэх, харилцах; ▪ Тухайн шинжлэх ухааны мэдлэгийг хэрэглэх; ▪ Судлах, шинжлэх; ▪ Даяаршил, дангааршил, тогтвортой хөгжил, эрүүл мэндийн боловсрол, иргэний боловсролын асуудлыг үндсэн хичээлийн агуулгатай холбох, интеграцчилах; ▪ Салбар дундын шинжлэх ухааны ололт амжилтаас суралцах, хэрэглэх; |

МОНГОЛ БАГШ²¹ (21-р зууны Монгол багш) загварыг хэрэгжүүлэх механизм

Уриа: “Хэлэлцэн тунгаах явцдаа хийж эхэлцгээе”



Долоо. Дүгнэлт

Ерөнхий боловсролын бодлогын зөвлөх багийн “Багшийн загвар” боловсруулах ажлын хэсгийн хийсэн энэхүү судалгаа нь өөрийн орны өнөөгийн нөхцөл байдал, бусад улс орны шинэ зууны эхээр боловсруулсан “багш” мэргэжилтний эзэмших чадамжийн бүтэцчилсэн хүрээ, загваруудыг харьцуулан судалж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр 21-р зууны Монгол багшийн загварыг боловсруулахад чиглэв.

Судалгаанаас багш боловсролын чанарыг сайжруулах бодлогын баримт бичгүүд гарч, олон хөтөлбөрүүд боловсрогдон хэрэгжиж байгаа боловч, багш боловсролын чанарт дорвитой ахиц гарахгүй, багш бэлтгэх сургууль төгсөгч-шинэ багш нар нь ЕБС-ийн шаардлагыг төдийлөн хангаж чадахгүй байгаа дутагдал харагдаж байна. Тухайлбал, 1-5 дахь жилдээ ажиллаж байгаа залуу багш нар ажилдаа сэтгэлээсээ, хариуцлагатай хандах чанар, бүтээлч байдал; бичиж боловсруулах, судалгаа хийх, үр дүнг нь сургалтандаа ашиглах, сургалтыг төлөвлөх, бусдаас суралцах, шүүмжлэлийг хүлээж авах, ашиглах чадвар дутмаг байна. Энэ нь нэг талаас, багш бэлтгэх сургуулийн сургалтын чанар, ялангуяа анхан шатны багш боловсрол (initial teacher education), төгсөгчийн чанарт тавих стандарт, улмаар багшийн ажлын гүйцэтгэлд тавих стандарт үгүйлэгдэж буйн илрэл юм. Нөгөө талаар, багш бэлтгэх сургалт, ер нь багшийн боловсролд чанарын шинэчлэл хийх стандарт шаардлагыг боловсруулахад тулгуурлах тодорхой загвар хэрэгтэй байгааг ч харуулж байна.

Судалгааны ажлын үр дүнг нэгтгэн дараах дүгнэлтийг хийж байна:

- Сингапур, Финлянд, АНУ зэрэг оронд багшийн ажлын гүйцэтгэлийн чанарыг түүнд тавих стандарттай харьцуулан үнэлж, багшлахуйд чанарын шинэчлэл хийж буй авууштай туршлага байна.
- “Багш” мэргэжлийн, ялангуяа багшлах эрхийн, шинэ багшийн стандартыг боловсруулахад чадамжид суурилсан загвар зонхилж, түүнд багш болох гэж буй хүн юу мэдэж, юүнд итгэж, юу хийх ёстой – г тодорхойлсон байх нь нийтлэг байна.
- Багш бэлтгэх, багшийг тасралтгүй хөгжүүлэх ажилд багшийн мэдлэгээс илүүтэй тэдний үр чадвар (зарим оронд гүйцэтгэл), ялангуяа үнэт зүйл, хандлагад тулгуурласан багшийн загвар зонхилж байна. Хөгжлийн эл чиг хандлагад үндэслэн багшийн эрхэмлэх зүйлд тулгуурласан загварыг боловсруулж, хэрэглэх нь зүйтэй гэж үзэж байна.
- Багшийн болон багш боловсролын загвар, багшийн эзэмших үндсэн чадамжийн хүрээ, багш мэргэжлийн стандарт боловсруулах ажлыг мэргэжлийн судалгааны байгууллагууд, багш нарын холбоод, багш бэлтгэх болон багш нарын мэргэжил дээшлүүлэх чиглэлээр ажилладаг дээд боловсролын байгууллагууд, бас багш нарын төлөөлөл оролцсон төслийн баг/ажлын хэсэг боловсруулж, өргөн хүрээнд хэлэлцүүлдэг бусад орны туршлагаас суралцах нь зүйтэй.

Найм. Санал, зөвлөмж

- Багшийн эрхэмлэх зүйл буюу үнэт зүйлд суурилсан загварыг багш нар, олон нийт, мэргэжлийн байгууллага, шинжээчдээр нээлттэй хэлэлцүүлэх,
- Монгол багш²¹ загварыг багш боловсролын стандарт, улмаар багшлах эрхийн, үндсэн ба ахисан түвшний багшийн стандарт боловсруулахад багшийн үндсэн чадамжийн бүтэцчилсэн хүрээг тогтооход ашиглах,
- Уг загварт тулгуурлан багш бэлтгэх сургуулийн багш боловсролын хөтөлбөрүүдэд агуулга, арга зүйн шинэчлэл хийх, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг шинэчлэх,
- Багш нарын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүдийн агуулгад багшийн эрхэмлэх үнэт зүйл, ажилдаа хандах эерэг хандлага, үндсэн чадамжийг эзэмших, хөгжүүлэх асуудлыг тусгах,
- Байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухаан, техник технологи, математик-мэдээлэл зүйн чиглэлээр тухайн судлагдахууныг судалж буй суралцагчдад тохиолддог нийтлэг саад бэрхшээл, гаргадаг түгээмэл алдаа, ташаа ойлголт (misconception) –ыг судалсан бусад орны дидактикчид, боловсрол судлаачдын бүтээлийг судлах, монгол суралцагчдын жишээн дээр судлах (case analyze) ажлыг багш бэлтгэх их, дээд сургуулиудын дидактикийн төвүүд, БСҮХ зэрэг судалгааны байгууллагуудын оролцоотой хамтарсан төслөөр гүйцэтгэх,
- Багш бэлтгэх, багш нарын мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөрт чанарын үнэлгээ хийх,
- Багшлах эрх олгох журмыг эргэн харах, багшлах эрхийн стандартыг хангасан тохиолдолд багшлах эрх олгодог бусад улс орны нийтлэг туршлагыг судлах,
- Багшийн ажлыг үнэлж дүгнэх журам (БСШУ-ны сайдын 2009 оны 561-р тушаал) нь үр дүн, чанарыг үнэлэх хэрэглэгдэхүүн болж чадаж буй эсэхийг нягтлан үзэх, шаардлагатай бол шинэчлэхийг тус тус санал болгож байна.

Ашигласан материал:

Andrew Pollard (2008) Reflective Teaching. UK.

Clarke, M. & Drudy, S. (2007). Social Justice in Initial Teacher Education: Student Teachers' Reflections.

Donald A. Schon (1983). The Reflective Practitioner: How Professionals Think in Action.

Энхтүвшин С., Баттуяа Ц., Сумъяа Ц., “Багш мэргэжлийн стандартын харьцуулсан судалгаа-2011”, УБ, 2011.

Эрдэнэчулуун Д., “Нэгжид суурилсан судалгааны үр дүнгээс”. УБ. 2003.

Forde et al, (2006). Literature Review on Teacher Education in the 21st Century.

Green Paper on Teacher Education in Europe (2000), TNTEE, Sweden Green Paper on Teacher Education in Europe (2000), TNTEE, Sweden

Жадамбаа Б., Батсуурь Ц., Пүрэв-Очир Б., Пүрэвдорж Д., “Багш боловсролын ирээдүй”, УБ. 2005.

InTASC Model Core Teaching Standards. USA. 2011.

Lawrence Stenhouse (1975). The Teacher Researcher.

Монгол улсын их хурлын 2008 оны 12-р тогтоолын хавсралт. “Монгол улсын мянган хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”. www.forum.mn/policyissue/NationalDevelopment/Strategy.doc.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 316-р тогтоолын 1-р хавсралт. “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”. www.mecs.gov.mn

Монгол улсын засгийн газрын 2010 оны 31-р тогтоолын хавсралт. “Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010-2021 он). www.mecs.gov.mn.

Монгол улсын засгийн газар, Боловсрол, шинжлэх ухааны яам, “Эрдэм боловсролтой Монгол хүн” Боловсрол шинжлэх ухааны салбарын чанарын шинэчлэлийн хөтөлбөр, 2012.

Монгол улсын стандарт. Дээд боловсрол. Мэргэжлийн чиглэл: Ерөнхий боловсролын сургуулийн багш. MNS 5323-95: 2009. Стандартчилал, Хэмжил зүйн газар. УБ. 2009.

Perrenoud, Ph. (1999). Dix nouvelles competences pour enseigner. Invitation au voyage. Paris: ESF.

Professional Standards for Teachers in England. Core standards – newly qualified teacher guidance. UK. 2007.

Pat Mahony, Ian Hextal (2000). Literature Review on Teacher Education in the 21st Century.

Synthesis report of the first homework of the Expert Group on Objective 1.1: Improving the education of teachers and trainers (WGI1.1/2/002).

Sylvia Chong, Horn Mun Chean. A Values, Skills and Knowledge Framework for Initial Teacher Preparation Programmes. National Institute of Education Singapore. 2009

Sylvia Chong, Pauline Ho. Quality teaching and learning: a quality assurance framework for initial teacher preparation programmes. *Int. J. Management in Education*. Vol. 3. Nos. 3/4. 2009

Scoping study on development of teaching standards in the broader Asia-Pacific Region. RFT PRN 14732. May 2008. Erebus International for the DEEWR.

Tennessee Teacher Licensure Standards: Professional Education. 2003.

The Standard for Initial Teacher Education in Scotland. 2000.

Сургалтын хөтөлбөрийн бүтэцчилсэн хүрээ, боловсролын стандарт боловсруулах техникийн туслалцаа, зөвлөх үйлчилгээ”, Эцсийн тайлан, 3-р боть, 4-р ном

